148

**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 25 өдөр Дугаар А/460 Мандалговь

МУ-ын үйлчилгээний гавьяат ажилтан
С.Пүрэвсүрэн, МУ-ын Аж үйлдвэрийн Ч.Дашбаатар нарыг
шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 2.1, 3.2.1 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15 хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

Нэг. "Дундговийн амьдрал" сонины эрхлэгч Сандагдоржийн Пүрэвсүрэн Төрийн дээд шагнал "Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан", Эрдэнэдалай сумын уугуул Чимэдцэрэнгийн Дашбаатар "Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан" цол хүртсэн тул аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнасугай.

Хоёр. Шагнал урамшууллын зардлыг хавсралтаар батласугай.

Гурав. Мөнгөн шагналд 900000 (есөн зуун мянга), Хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 70000 (далан мянга), нийт 970000 (Есөн зуун далан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488191250

Аймгийн Засаг даргын 2019 оны
.12. дугаар сарын .25.....-ны өдрийн А/460..дугаар
захирамжийн хавсралт

ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Овог, нэр | Ажил, албан тушаал, сургууль | Хүртсэн шагнал, гаргасан амжилт | Шагналын болон зардлын мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Сандагдорж Пүрэвсүрэн | "Дундговийн амьдрал" сонины эрхлэгч | Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан | 500000 |
| 2 | Чимэдцэрэн Дашбаатар | Нүүрэнтэй илч ТББ-ын тэргүүн | Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан | 400000 |
| 3 | Хүндэт өргөмжлөл хийлгэх | | | 70000 |
| | Нийт | | | **970000** |